

**7 дугаар бүлэгт дурдсан  
4 дүгээр хавсралт**

**Санхүүгийн үйлчилгээ**

**1 дүгээр зүйл  
Хамрах хүрээ**

Энэхүү хавсралт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх арга хэмжээнд хамаарна. Энэхүү хавсралтад дурдсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх гэдэг нь 7.2 дугаар зүйлийн (m) дэд хэсэгт тодорхойлсны дагуу үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

**2 дугаар зүйл  
Тодорхойлолт**

1. Энэхүү хавсралтын зорилгоор:

- (a) “санхүүгийн үйлчилгээ” гэх нэр томъёо нь нэг Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй санхүүгийн шинжтэй аливаа үйлчилгээг хэлнэ. Санхүүгийн үйлчилгээнд даатгалын болон даатгалтай холбоотой үйлчилгээ, мөн банкны болон санхүүгийн бусад (даатгалаас бусад) бүх үйлчилгээ хамаарна. Санхүүгийн үйлчилгээнд дараахь үйл ажиллагаа багтана:
  - (i) даатгалын болон даатгалтай холбоотой үйлчилгээ:
    - (A) шууд даатгал (хамтарсан даатгалыг оролцуулан):
      - (aa) амь насны;
      - (bb) амь насны даатгалаас бусад даатгал;
    - (B) давхар даатгал, ретроцесс (retrocession);
    - (C) зуучлагч болон төлөөлөгч зэрэг даатгалын зуучлал;
    - (D) зөвлөгөө өгөх, актуар тооцооллын үйлчилгээ, эрсдлийн үнэлгээ болон нөхөн төлбөр шийдвэрлэх үйлчилгээ зэрэг даатгалыг дагалдах бусад үйлчилгээ.

- (ii) банкны болон санхүүгийн бусад үйлчилгээ (даатгалаас бусад):
- (A) олон нийтээс хадгаламж болон бусад эргэн төлөгдөх мөнгөн хөрөнгийг хүлээн авах;
  - (B) хэрэглээний зээл, ипотекийн зээл, арилжааны хэлцлийн санхүүжилт болон факторинг гэх мэт бүхий л төрлийн зээл;
  - (C) санхүүгийн лизинг;
  - (D) кредит, тооцооны болон дебит карт, замын чек, банкны вексел зэрэг бүх төрлийн төлбөрийн болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
  - (E) баталгаа болон төлбөрийн хариуцлага;
  - (F) биржээр, эсхүл биржийн бус зах зээлд, эсхүл бусад байдлаар, өөрийн дансаар, эсхүл үйлчлүүлэгчийн дансаар дараахийг арилжих:
    - (aa) мөнгөний зах зээлийн хэрэгсэл (чек, шилжүүлэх вексел, хадгаламжийн сертификат оролцуулан);
    - (bb) гадаад валют;
    - (cc) фьючерс, опцион зэрэг гэхдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл;
    - (dd) своп хэлцэл, ханшны форвард хэлцэл зэрэг валютын ханш, хүүгийн хэрэгсэл;
    - (ee) шилжүүлж болох үнэт цаас;
    - (ff) алт, мөнгөн гулдмай зэрэг арилжиж болохуйц бусад хэрэгсэл, санхүүгийн актив;
  - (G) нээлттэй, эсхүл хаалттай арилжаа эсэхээс үл хамааран, андеррайтинг болон төлөөлөгчөөр байршуулах зэргээр төрөл бүрийн үнэт цаас гаргахад оролцох, мөн түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх;

- (H) мөнгөний зах зээл дээр брокерийн үйл ажиллагаа явуулах;
  - (I) бэлэн мөнгө буюу үнэт цаасны багцын удирдлага, хамтын хөрөнгө оруулалтын удирдлагын бүх төрөл, тэтгэврийн сангийн удирдлага, кастодианы, хадгаламжийн болон итгэмжлэлийн үйлчилгээ зэрэг хөрөнгийн удирдлага;
  - (J) үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон бусад арилжиж болохуйц хэрэгслүүдийн төлбөр, тооцооны үйлчилгээ;
  - (K) санхүүгийн мэдээллээр хангах болон дамжуулах, санхүүгийн тоо баримтын боловсруулалт болон бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох програм хангамж;
  - (L) зээлийн асуудлаарх лавлагаа ба судалгаа шинжилгээний материал, шууд ба багцын хөрөнгө оруулалтын талаарх судалгаа ба зөвлөмж, корпорацийг эзэмших, өөрчлөн байгуулах болон стратегийн талаарх зөвлөгөө өгөх зэрэг (A)-аас (K) дэд хэсэгт дурдсан үйл ажиллагааны бүх төрлийн хувьд зөвлөгөө өгөх, зуучлах болон санхүүгийн туслах бусад үйлчилгээ.
- (b) “санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч” гэх нэр томъёо нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэх сонирхолтой, эсхүл үзүүлж буй этгээдийг хэлэх бөгөөд үүнд төрийн байгууллага хамаарахгүй;
- (c) “санхүүгийн шинэ үйлчилгээ” гэх нэр томъёо нь одоо байгаа болон шинэ бүтээгдэхүүн, эсхүл бүтээгдэхүүнийг хүргэж буй арга хэлбэртэй холбоотой үйлчилгээ зэрэг санхүүгийн шинжтэй үйлчилгээ бөгөөд аль нэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэг Талын нутаг дэвсгэрт үзүүлдэггүй боловч нөгөө Талын нутаг дэвсгэрт, эсхүл Дэлхийн Худалдааны Байгууллагын бусад гишүүдийн нутаг дэвсгэрт үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ;
- (d) “төрийн байгууллага” гэх нэр томъёо нь:

- (i) нэг Талын Засгийн газар, төв банк, эсхүл мөнгөний бодлогын асуудал эрхэлсэн байгууллага, эсхүл тухайн Талын эзэмшлийн, эсхүл хяналт бүхий байгууллага бөгөөд засгийн газрын чиг үүргийг гол төлөв хэрэгжүүлдэг, эсхүл засгийн газрын хүрээний чиг үүрэг, эсхүл үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг хэлнэ. Үүнд арилжааны нөхцөлөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ажлыг гол төлөв эрхэлдэг байгууллага хамаарахгүй;
  - (ii) төв банк, эсхүл мөнгөний бодлогын асуудал эрхэлсэн байгууллагын зүгээс хэрэгжүүлдэг тэдгээр чиг үүргийг гүйцэтгэж байгаа хувийн байгууллага.
- (e) “өөрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллага” гэх нэр томьёо нь аливаа төрийн бус байгууллагыг хэлэх бөгөөд үүнд үнэт цаасны, эсхүл фючерсийн бирж буюу зах зээл, тооцооны төлөөлөгч, эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийн, эсхүл эрх олгогдсон зохицуулалтын буюу хяналтын эрх мэдлээ хэрэгжүүлдэг аливаа байгууллага, эсхүл холбоо багтана.
2. (a) 7.1 дүгээр зүйлийн 2(g) дэд хэсэгтэй холбоотойгоор “засгийн газрын эрх мэдлийн хүрээнд нийлүүлж буй үйлчилгээ” гэх нэр томьёонд дараахь санхүүгийн үйлчилгээ хамаарна:
- (i) мөнгөний буюу валютын ханшны бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төв банк, эсхүл мөнгөний бодлогын асуудал эрхэлсэн байгууллага, эсхүл төрийн бусад байгууллагын явуулж буй үйл ажиллагаа;
  - (ii) нийгмийн халамж, эсхүл нийтийн тэтгэврийн төлөвлөлтийн эрх зүйн тогтолцооны нэг хэсгийг бүрдүүлж буй үйл ажиллагаа;
  - (iii) Засгийн газрын санхүүгийн эх үүсвэрийг ашиглан, эсхүл баталгаатай, эсхүл нэрийн өмнөөс явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагаа.

- (b) 7.1 дүгээр зүйлийн 2 (g) дэд хэсгийн хүрээнд, хэрэв аль нэг Тал (a) (ii), эсхүл (a) (iii) дэд хэсэгт дурдсан аль нэг үйл ажиллагааг төрийн байгууллага, эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчтэй өрсөлдөх байдлаар явуулахыг зөвшөөрсөн бол “засгийн газрын эрх мэдлийн хүрээнд нийлүүлж буй үйлчилгээ” гэдэгт тухайн үйл ажиллагаа үл хамаарна.
- (c) 7.2 дугаар зүйлийн (k) дэд хэсэг нь энэхүү хавсралтад хамаарч буй үйлчилгээнд хамаарахгүй.

### **3 дугаар зүйл Дотоодын зохицуулалт**

1. 7 дугаар бүлэг, эсхүл түүний хавсралтад дурдсан бусад заалтыг үл харгалзан аль нэг Тал нь зайлшгүй шалтгаанаар дараахь байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах, эсхүл хэрэгжүүлэхэд саад учрахгүй:

- (a) хөрөнгө оруулагч, хадгаламж эзэмшигч, даатгалын гэрээ эзэмшигч, эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн итгэмжлэгдсэн этгээдийг хамгаалах;
- (b) тухайн Талын санхүүгийн тогтолцооны бүрэн бүтэн, тогтвортой байдлыг хангах.

2. Хэрэв эдгээр арга хэмжээ нь 1 дэх хэсэгт заасантай нийцэхгүй бол холбогдох Тал тухайн арга хэмжээг дээрх зохицуулалтаар хүлээсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийх хэрэгсэл болгон ашиглахгүй.

3. 7 дугаар бүлэг, эсхүл түүний хавсралт нь аль нэг Талын хувь хүний тодорхой хэрэг болон данстай холбоотой мэдээлэл, эсхүл төрийн байгууллагын мэдэлд байгаа аливаа бусад нууц, эсхүл хувийн өмчлөлийн мэдээллийг задруулахыг шаардах байдлаар тайлбарлахгүй.

#### **4 дүгээр зүйл**

### **Санхүүгийн шинэ үйлчилгээ**

Аль нэг Тал нь өөрийн нутаг дэвсгэрт байгуулагдсан нөгөө Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийг тухайн Талын нутаг дэвсгэрт санхүүгийн аливаа шинэ үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрнө. Гэхдээ энэхүү хавсралт нь тухайн Талыг өөрийнх нь хуулиар тусгайлан эрх олгоогүй санхүүгийн шинэ үйлчилгээнд зөвшөөрөл олгох зорилгоор захиргааны салбар, зохицуулах хороо, эсхүл төв банкнаас тогтоол гаргах, эсхүл аливаа төрлийн зохицуулалт хийхийг хориглохгүй.

Тайлбар: 7.5 дугаар зүйлийн 2 (е) дэд хэсгийг үл харгалзан энэхүү хавсралтын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүрээн дэх зайлшгүй шаардлагаар аль нэг Тал нь тухайн санхүүгийн шинэ үйлчилгээг үзүүлэх зохион байгуулалтын болон эрх зүйн хэлбэрийг тодорхойлж, уг үйлчилгээг үзүүлэх зөвшөөрөл авахыг шаардаж болно.

#### **5 дугаар зүйл**

### **Төлбөр, тооцооны систем**

Үндэсний нөхцөл олгодог нөхцөл, шаардлагын дагуу аль нэг Тал нь өөрийн нутаг дэвсгэрт байгуулагдсан нөгөө Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид төрийн байгууллагын эрхэлдэг төлбөр, тооцооны систем болон бизнесийн ердийн үйл ажиллагаа явуулахад үзүүлэх санхүүгийн болон дахин санхүүжилт хийх тогтолцоонд нэвтрэх зөвшөөрлийг олгоно. Энэхүү заалтыг аль нэг Талын эцсийн зээлдүүлэгчийн хэрэгсэлд нэвтрэх зөвшөөрөл олгох зорилгоор тусгаагүй болно.

#### **6 дугаар зүйл**

### **Өөрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллага**

Хэрэв:

- (а) тухайн Тал нөгөө Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь тухайн Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчтэй эрх тэгш нөхцөлөөр санхүүгийн үйлчилгээ явуулахад өөрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллагын гишүүнчлэл, эсхүл оролцоог шаардах бол;

- (b) тухайн Тал санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд уг байгууллагад шууд болон шууд бус байдлаар эрх мэдэл, эсхүл давуу байдал олгодог бол,

тухайн Тал нь дээрх байгууллагыг тухайн Талын нутаг дэвсгэрт байрладаг нөгөө Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид үндэсний нөхцөл олгох явдлыг хангана.

## **7 дугаар зүйл** **Ил тод байдал**

1. Тал бүр санхүүгийн үйлчилгээнд зохицуулалтын ил тод байдлыг дэмжинэ. Үүний дагуу Талууд ил тод зохицуулалтын журмыг тус бүртээ хэрэгжүүлэх зорилгоор Талууд дараахь нөхцөлийг харгалзан үзэж, зохих тохиолдолд харилцан зөвлөлдөнө:

- (a) ҮХЕХ болон санхүүгийн үйлчилгээний худалдаатай холбоотой бусад хүрээнд гүйцэтгэх ажил;
- (b) зохицуулалтын ил тод байдал, бодлогын зорилгын тодорхой байдал болон зохицуулалтын журмыг олон нийтэд түгээх буюу бусад хэлбэрээр нээлттэй болгох, мөн түүнийг ойлгомжтой, тууштай хэрэгжүүлэх ач холбогдол.

2. Тал бүрийн эрх бүхий байгууллага нь санхүүгийн үйлчилгээний худалдаатай холбоотой өргөдөл гаргахад тавих шаардлага, журмыг сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу аль болох боломжоороо нээлттэй болгоно.

3. Хэрэв санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тухайн Талын эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, журмыг олон нийтэд нээлттэй болгоно. Тухайн Талын хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд гэж үзсэн өргөдлийг шийдвэрлэхэд зарцуулах энгийн хугацааг мөн олон нийтэд нээлттэй болгоно.

4. Тал бүр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй энэхүү хавсралтад дурдсан асуудлаар нийтээр дагаж мөрдөх аливаа журам болон журмын зорилгын тухай аль болох боломжоороо урьдчилан нийтэлнэ.

Тайлбар: Илүү ойлгомжтой болгох зорилгоор, энэ хэсэгт дурдсан журмыг урьдчилан нийтлэхэд, тухайн Тал нь сонирхсон этгээд болон нөгөө Талд цахим, эсхүл өөр бусад хэлбэрээр саналаа илэрхийлж болох холбоо барих хаягийг олгоно.

5. Тал бүр өөрийн үйл ажиллагааг зохицуулах байгууллагын баталсан, эсхүл хэрэгжүүлж буй нийтээр дагаж мөрдөх журмыг сонирхогч этгээдэд танилцах боломж олгохуйц хэлбэрээр шуурхай нийтлэх, эсхүл нээлттэй болгохыг эрмэлзэнэ.

## **8 дугаар зүйл**

### **Өргөдөл гаргах журам**

1. Талуудын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой өргөдлийг хугацаа алдалгүй хянан үзнэ.

2. Хэрэв нэг Талын эрх бүхий байгууллага өргөдлийг хянан үзэхэд өргөдөл гаргагчаас нэмэлт мэдээлэл шаардлагатай гэж үзвэл өргөдөлд нэмж бүрдүүлэх шаардлагын талаар өргөдөл гаргагчид хугацаа алдалгүй мэдэгдэнэ.

3. Хэрэв нэг Талын эрх бүхий байгууллага өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу татгалзсан шалтгаанд тайлбар хийнэ.

4. Хэрэв санхүүгийн үйлчилгээг үзүүлэхэд тусгай зөвшөөрөл шаардлагатай бөгөөд тухайн тусгай зөвшөөрлийг олгоход тавих шаардлагыг хангасан бол тухайн Талын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд гэж үзсэн өргөдлийг зарчмын хувьд хүлээн авснаас зургаан сарын дотор өргөдөл гаргагчид тусгай зөвшөөрлийг олгоно. Хэрэв зургаан сарын дотор шийдвэр гаргах боломжгүй бол эрх бүхий байгууллагаас үүнээс хойших боломжтой хугацаанд шийдвэр гаргахыг эрмэлзэнэ.

## **9 дүгээр зүйл**

### **Үр дүнтэй, ил тод зохицуулалт**

Талууд өөрийн нутаг дэвсгэрт Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”, Даатгалын хяналт шалгалтын олон улсын холбооны стандарт болон зарчим болон Үнэт цаасны олон улсын байгууллагын “Үнэт цаасны зохицуулалтын зорилго ба зарчим”-ын хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт гаргана.



## **10 дугаар зүйл**

### **Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүлээн зөвшөөрөх**

Аль нэг Тал хэлэлцээр буюу тохиролцооны үндсэн дээр энэхүү хэлэлцээрийн оролцогч бус тал, эсхүл аливаа олон улсын зохицуулалтын байгууллагын зайлшгүй арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн Талын санхүүгийн үйлчилгээтэй холбоотой арга хэмжээнүүд хэрхэн хэрэгжихийг тодорхойлохдоо, тухайн зохицуулалтын хяналт, хэрэгжилт мөн хэлэлцээр болон тохиролцоонд оролцогч талуудын хооронд мэдээлэл солилцох шат дамжлагатай дүйцэхүйц арга байлгах нөхцөлийн хүрээнд, тухайн Тал нь нөгөө Талд тэрхүү хэлэлцээр, эсхүл тохиролцоонд оролцохоор хэлэлцээ хийх, эсхүл түүнтэй дүйцэхүйц хэлэлцээр, эсхүл тохиролцоо байгуулах зохих боломжийг олгоно. Хэрэв аль нэг Тал тэрхүү зөвшөөрлийг бие даан олгодог бол нөгөө Талыг уг нөхцөл байдал оршиж байгааг нотлох хангалттай боломжийг олгоно.

## **11 дүгээр зүйл**

### **Мэдээлэл дамжуулах, боловсруулах**

Талууд өөрийн нутаг дэвсгэрт орох, нутаг дэвсгэрээс гарах цахимаар өгөгдөл дамжуулахыг оролцуулан санхүүгийн мэдээллийг боловсруулах, эсхүл олон улсын хэлэлцээртэй нийцсэн импортын дүрмийн дагуу мэдээлэл дамжуулах, түүнчлэн нөгөө Талын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч бизнесээ хэвийн явуулахад шаардлагатай мэдээлэл дамжуулах, санхүүгийн мэдээллийг боловсруулах, эсхүл тоног төхөөрөмж дамжуулах зэрэг шилжүүлгийг зогсоох арга хэмжээг авахгүй. Энэхүү зүйлийн аль ч заалт аль нэг Талын хувь хүний мэдээлэл, хувийн асуудал, хувийн мэдээллийн болон дансны нууцлалыг хамгаалах эрхийг хязгаарлахгүй бөгөөд энэ эрх нь 7 дугаар бүлэг, эсхүл түүнд дурдсан хавсралтын заалтаас зайлсхийхээр ашиглагдахгүй.

## **12 дугаар зүйл**

### **Маргаан шийдвэрлэх**

Урьдчилан сэргийлэх асуудал болон санхүүгийн маргаантай бусад асуудалтай холбоотойгоор 16.6 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан арбитрын шүүх нь тухайн маргаантай санхүүгийн үйлчилгээний асуудлаар шаардлагатай хэмжээнд мэргэшсэн байна.